

III. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГО

15. Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцааны бодлогын үндсэн зорилго нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын үндсэн дээр тус Улсын эдийн засгийн хэтийн болон цаг үеийн зорилтыг зохистой шийдвэрлэхэд гадаад хүчин зүйлийг оновчтой ашиглах, улмаар улс орны эдийн засгийг бүс нутгийн интеграцид оорийн гэсэн байр суурьтай болгоход оршино.

16. Гадаад улс орнуудтай эдийн засгийн харилцаа хөгжүүлэх, хамтран ажиллахдаа эдийн засгийн аюулгүй байдалд сорог нолоо үзүүлэх, аль нэг орноос хэт хараат байдалд орохоос сэрэмжлэхийн хамт олон улсын аж ахуйн харилцааны зарчим, хэм хэмжээг баримтлан эрх тэгш, харилцан ашигтай байх, хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх, улс төрийн болон бусад даралт шахалтад автахгүй байх ноцол бүрдүүлэх бодлого явуулна.

17. Эдийн засаг, гааль, худалдааны тусгай бүс байгуулах, хамтарсан буюу гадаадын дагнасан хоронго оруулалттай үйлдвэр байгуулах, концесс олгох зэрэг хотолборийг улс төр, эдийн засгийн үр дагаврыг нь нарийн тооцож үндэсний аюулгүй байдалд хохирол учруулахгүй, эдийн засгийн үр ашигтай байхуйцаар ашиглана.

18. Үндэсний ашиг сонирхолд ихээхэн нолоо бүхий төслийг хэрэгжүүлэхдээ хамтран ажиллах улс буюу тэнхийг улс төрийн ашиг сонирхлын үүднээс сонгохыг чухалчилна.

19. Гадаад орийн асуудлыг улс орны эдийн засгийн аюулгүй байдалд хохиролгүйгээр зохицуулж, зээлийг эгүүлэн толох баталгааг нь нарийн тооцож зөв тогтоосны үндсэн дээр авч, үр дүнтэй ашиглана.

20. Монгол Улс эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлэхдээ дараах үндсэн чиглэл баримтална:

1/ эдийн засгийн гадаад харилцааны үйл ажиллагааг улс орны эдийн засгийн чадавхи,

экспортын чиглэлийн нооцийг осгон нэмэгдүүлэх, эдийн засгийн дэд бүтцийг бүрэлдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

2/ Монгол Улсын эдийн засгийн түүхий эд зонхилсон чиглэлийг оорчилж, оновчтой бүтцийг бүрэлдүүлэхэд чиглэсэн үндсэн салбаруудыг хөгжүүлэх шаардлагатай уялдуулан эрдсийн болон мал, амьтан, ургамлын гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшинг хамгийн үр ашигтай хэмжээнд хүргэж, дэлхийн зах зээлд орсолдох бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

3/ одоо байгаа үйлдвэрүүдийг орчин үеийн шилдэг техник, технологиор шинэчлэн тоноглох, хүнс, хонгон үйлдвэр, уул уурхай, хими, биотехнологи, шинэ материалын зэрэг экспортын чиглэлтэй аж үйлдвэрийг оорийн орны түүхий эдэд тулгуурлан хөгжүүлэх чиглэл баримтлах;

4/ экспортын чадавхийг дээшлүүлэхдээ алт, зэс, молибден, уран зэрэг эрдэс түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ходоо аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бүрэн боловсруулж, дэлхийн зах зээлд орсолдох бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд гадаад орнуудтай хамтран ажиллах;

5/ монголын экспортын бүтээгдэхүүний зах зээлийг орготгох;

6/ улс орны түлш-эрчим хүч, зам тээвэр, харилцаа холбоо зэрэг дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх, далайн боомт хүрэх, дамжин онгорох зам тээврийн таатай ноцол бүрдүүлэх;

7/ олон улсын, ялангуяа Зүүн-хойд Азийн зам, тээвэр, мэдээлэл, харилцаа, холбооны сүлжээнд нэгдэж орох;

8/ импортыг орлуулах бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлтэй дунд, жижиг үйлдвэрийг хөгжүүлэхэд гадаадын зээл тусламж, технологи авах бодлого баримтлах;

9/ монгол орны байгаль, тvvх, соёлын ов санд тvшиглэн олон улсын аялал жуулчлалыг хогжvвлэх, материаллаг баазыг нь бэхжvвлж, вйлчилгээг дэлхийн тvшинд хvргэх;

10/ гадаад худалдааны нэн тааламжтай нохцол олох, хонгололттэй зээл, буцалтгвй тусламж авах статусыг тодорхой хугацаанд хадгалах.